



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 01 сарын 11 өдөр

Дугаар А/14

Арвайхээр


Олон нийтийн төлөөллийг сонгон
шалгаруулах хороо байгуулах тухай

Эрүүл мэндийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хуулийн 15 дугаар зүйл, Эрүүл мэндийн сайдын 2017 оны “Журам батлах тухай” А/189 дугаар тушаалаар батлагдсан журмын 1.2.2, Эрүүл мэндийн сайдын 2018 оны “Үлгэрчилсэн дүрэм батлах тухай” А/476 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлгийн төлөөлөн удирдах зөвлөлийн үлгэрчилсэн дүрэм”- ийн 4.1.3 дугаар заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн олон нийтийн төлөөллийг сонгон шалгаруулах хорооны бүрэлдэхүүнийг нэгдүгээр, Хархорин сумын Нэгдсэн эмнэлгийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн олон нийтийн төлөөллийг сонгон шалгаруулах хорооны бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Төлөөлөн удирдах зөвлөлийн олон нийтийн төлөөллийг сонгон шалгаруулах үйл ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулахыг ажлын хорооны ахлагч (Б.Сайнжаргал)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100042

Аймгийн Засаг даргын 2019... оны 01...
дугаар сарын 11...ны өдрийн 11/11 дугаар
захирамжийн нэгдүгээр хавсралт

**БҮСИЙН ОНОШИЛГОО, ЭМЧИЛГЭЭНИЙ ТӨВИЙН ТӨЛӨӨЛӨН
УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ОЛОН НИЙТИЙН ТӨЛӨӨЛЛИЙГ
СОНГОН ШАЛГАРУУЛАХ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН**

Ахлагч: Б.Сайнжаргал- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын
хэлтсийн дарга

Гишүүд: Б.Валя - Аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газрын ахлах
нягтлан бодогч

Х.Энхжаргал –Аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн
даатгалын хэлтсийн дарга

Д.Болормаа – Аймгийн Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн
Чанарын албаны дарга

Б.Ганбат - Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч
(зөвшилцсөнөөр)

Т.Нарангарав - Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч
(зөвшилцсөнөөр)

Б.Туяацэцэг – Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын
албаны Орон нутгийн бодлого зохицуулалтын тасгийн дарга

Аймгийн Засаг даргын 2019..... оны 01...
дугаар сарын 11.....ны өдрийн А/Ш дугаар
захирамжийн хоёрдугаар хавсралт

**ХАРХОРИН СУМЫН НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ОЛОН НИЙТИЙН ТӨЛӨӨЛЛИЙГ СОНГСН ШАЛГАРУУЛАХ
ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН**

Ахлагч: Б.Сайнжаргал- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын
хэлтсийн дарга

Гишүүд: Б.Валя - Аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газрын ахлах
нягтлан бодогч

Х.Энхжаргал -Аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн
даатгалын хэлтсийн дарга

Д.Долгор -Хархорин сумын Нэгдсэн эмнэлгийн эмчилгээ эрхэлсэн
орлогч дарга

Б.Ганбат - Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч
(зөвшилцсөнөөр)

Т.Нарангарав - Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч
(зөвшилцсөнөөр)

Б.Туяацэцэг – Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын
албаны Орон нутгийн бодлого зохицуулалтын тасгийн дарга